ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.01 № 1/60

танай ______-ны № ______-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Сумын төвийг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах" ажил /Ханх сум/ -ын зураг, төсөл боловсруулах ХӨАОНӨГ/202212125-зөвлөх дугаартай худалдан авах ажиллагааг шууд худалдан авалтын аргаар сонгож гэрээ байгуулах ажлын хэсгийн шийдвэрийг хянаад доор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна. Уг зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг нь Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан журмын босго үнийг хангаж байгаа тул шууд худалдан авах аргыг сонгосон болно.

Уг зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад "Криетив Монголиа" ХХК 7,950,000 төгрөгийн санхүүгийн саналтай тендерийг ирүүлсэн байна.

"Сумын төвийг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах" ажил /Ханх сум/ -ын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад "Криетив Монголиа" ХХК-ийн ирүүлсэн 7,950,000 (долоон сая есөн зуун тавин мянган) төгрөгийн үнийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж гэрээ байгуулна уу.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

d/A4

001760046

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.11 № 1/76

танай 2022.02.10 -ны № 104 -т

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА М.ҮҮРИЙН БАЯР
ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Сумдын эрүүл мэндийн төвд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох тендерийг зарлуулах тухай танай байгууллагын 2022 оны 104 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлттэй танилцлаа.

Манай газар нь аймгийн 2022 оны төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан журмад заасан хугацаа буюу 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр www.tender.gov.mn сайтад байршуулж сангийн сайдаар батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөнд сумдын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах захиалга нэгтгэгдээгүй тул төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалтыг зохион байгуулах боломжгүй байна.

Иймд сумдын эрүүл мэндийн төвд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд аймгийн Эрүүл мэндийн газрын эрхээр нийтэлж, эрх бүхий байгууллагаар батлуулан манай газарт худалдан авах ажиллагааны эрхийг уг цахим системээр шилжүүлэхийг зөвлөж байна.

Сумдын эрүүл мэндийн төвийн хэрэгцээнд худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг манай газарт цахим системээр шилжүүлсэн тохиолдолд худалдан авалтыг зохион байгуулах боломжтой болохыг мэдэгдье.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

d/A4

001760052

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.16 № 1/90

танай _______ -ны № _______ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Төрийн үйлчилгээний E-mongolia системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх (Сумдын архив, бичиг хэргийн ажилтны тоног төхөөрөмж) ажлын гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212061 дугаартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгууллаа.

Уг төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад нэг ч оролцогч оролцохгүй байгаа тул уг төсөл арга хэмжээний ажлын даалгавар, тоо хэмжээ, төсвийг дахин судалсны үндсэн дээр худалдан авах ажиллагааг дахин зарлах үнэлгээний хорооны шийдвэр гарлаа.

Иймд манай газарт Төрийн үйлчилгээний E-mongolia системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх (Сумдын архив, бичиг хэргийн ажилтны тоног төхөөрөмж) ажлын даалгавар, тоо хэмжээ, төсвийг мэргэжлийн байгууллагаар дахин хянуулж, эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан ирүүлнэ үү.

Ажлын даалгавар дахин батлагдаж ирэхгүй удааширснаас үүссэн эрсдэлийг манай газар хариуцахгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

d/A4

6712010001

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.16 № 1/91

танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга (Мөрөн сум, 5, 6, 12 дугаар баг)-ын зураг төсөл, инженер геологийн дүгнэлт боловсруулах 20,000 (Хорин сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий зөвлөх үйлчилгээ шууд худалдан авалтын аргаар нийлүүлэх урилгыг “Өрнөх гүнт” ХХК, “Грийнпайнт тийм” ХХК, “БА-ББ” ХХК-д тус тус хүргүүлсэн боловч “Грийнпайнт тийм” ХХК-аас бусад компани үнийн санал ирүүлээгүй байна.

“Грийнпайнт тийм” ХХК нь өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга (Мөрөн сум, 5, 6, 12 дугаар баг)-ын зураг төсөл, инженер геологийн дүгнэлт боловсруулах зөвлөх үйлчилгээг 18,400 (Арван найман сая дөрвөн зуун мянган) төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлснийг зөвшөөрч, Монгол Улсын засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг үндэслэн тус компанитай шууд худалдан авалтын аргаар гэрээ байгуулах эрх олгохыг зөвлөж байна.

Шууд худалдан авалтын аргаар гэрээ байгуулах тул Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга (Мөрөн сум, 5, 6, 12 дугаар баг)-ын зураг төсөл, инженер геологийн дүгнэлт боловсруулах зөвлөх үйлчилгээг нийлүүлэх гэрээг 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс өмнө байгуулж болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

d/A4
6712010002

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.16 № 1/92

танай ______-ны № ______-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжихээр батлагдсан Байгаль хамгаалагчдын унаа, техник хэрэгсэл, нормын хувцсаар хангах гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212091/4.4.1 дугаартай худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох Багц-1 Байгаль хамгаалагч, албан хаагчдыг нормын хувцасаар хангах тендер шалгаруулалтад “Хотулун бэхи групп” ХХК 38,500,000 төгрөгийн үнийн саналтай тендер ирүүлсэн байна.

Багц-1 Байгаль хамгаалагч, албан хаагчдыг нормын хувцсаар хангах ажлыг 38,500,000 (Гучин найман сая таван зуун мянган) төгрөгөөр гүйцэтгэхээр “Хотулун бэхи групп” ХХК-ийн ирүүлсэн тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулллаа.

Иймд уг төсөлд “Хотулун бэхи групп” ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дэх заалтын дагуу гэрээ байгуулна уу.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6, Аймгийн ИТХ-ын 2013 оны 43 дугаар тогтоолын дагуу чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100-170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгааг гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

6715129361 4131053

d/A4
6712010004

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.16 № 1/95

танай ______ -ны № ______ -т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Эко био нойл худалдан авах ажиллагааг зохион байгуулж өгнө үү гэх танай байгууллагын 2022 оны 2 дугаар сарын 15-ний өдрийн 84 дүгээр албан бичигтэй танилцлаа.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хөвсгөл аймаг дахь сонгогдсон байршилд 12 ш нүхэн жорлон барих 38,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий арга хэмжээг Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын 2021 оны А/29 дүгээр тушаалаар баталж, аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна.

Тус арга хэмжээ нь нүхэн жорлон барих ажил худалдан авах тендер шалгаруулалт байхаар сайдын тушаалаар батлагдсан байхад танай байгууллагаас гаргасан ажлын даалгаварт Эко био нойл (Байгууламж) худалдан авахаар заасан нь төсөл арга хэмжээний нэртэй зөрчилдөж байна.

Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын 2021 оны А/29 дүгээр тушаалаар баталсан төсөл арга хэмжээний нэртэй нийцүүлж "нүхэн жорлон барих" ажлын зураг төсөл гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Манай газар нь аймгийн 2022 оны төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан журмад заасан хугацаа буюу 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр www.tender.gov.mn сайтад байршуулж Сангийн сайдаар батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөнд Хөвсгөл аймаг дахь сонгогдсон байршилд 12 ш нүхэн жорлон барих ажил худалдан авах төлөвлөгөө нэгтгэгдээгүй тул төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалтыг зохион байгуулах боломжгүй байна.

Түүнчлэн дээрх арга хэмжээг Сайдын баталсан төсөл арга хэмжээний нэрэнд нийцүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд Хөвсгөл аймаг дахь сонгогдсон байршилд 12 ш нүхэн жорлон барих ажил худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд Байгаль орчин аялал жуулчлалын газрын эрхээр нийтэлж эрх бүхий байгууллагаар батлуулан манай газарт цахимаар эрхийг нь шилжүүлэхийг зөвлөж байна.

Хөвсгөл аймаг дахь сонгогдсон байршилд 12 ш нүхэн жорлон барих ажил худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг манай газарт цахимаар шилжүүлсэн тохиолдолд худалдан авалтыг зохион байгуулах боломжтой болохыг мэдэгдье.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

d/A4

6712010006

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.18 № 1/96
танай ______-ны № ______-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Авто машин худалдан авах /Тариалан сум/ гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212072 дугаартай худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад "Арвайн нөөлөг" ХХК 58,200,000 төгрөгийн үнийн саналтай тендер ирүүлсэн байна.

"Арвайн нөөлөг" ХХК -ийн ирүүлсэн тендер нь (ТШЗ)-ын 16.2.4-ын 1, 2, (ТШЗ)-ын 16.6-ын 1, (ТШЗ)-ын 16.6.4 дэх заалтуудыг хангахгүй байгаа тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтын дагуу шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.18 № 1/97

танай ______-ны № ______-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Гэр хорооллын ус түгээх цэгүүдийн ус нөөцлөх савыг MNS 6148:2010 стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх /Мөрөн сум/ гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212082 дугаартай худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “Ирмүүн Бармат” ХХК 60,400,000 төгрөгийн үнийн саналтай тендер ирүүлсэн байна.

“Ирмүүн Бармат” ХХК -ийн ирүүлсэн тендер нь ТШЗ-ын 16.6.6-ын 4 дэх заалтын хангахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг хангахгүй байгаа тул мөн хуулийн 27.4 дэх заалтын дагуу шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

d/A4

6712010008

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.21 № 1/104.
танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллагын хүсэлтийн дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт БҮТЭЗ /Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл/ нийлүүлэх ХӨАНЭ/202201023/ дугаартай тендерийг www.tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад доор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт БҮТЭЗ нийлүүлэх ХӨАНЭ/202201023/ дугаартай тендер шалгаруулалтад:

Багц 1: Цэвэрлэгээний материал багцад нэг ч оролцогч ороогүй байна.

Багц 2: Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 10,608.000 төгрөгний багцад "Санаа мед трейд " ХХК 10,600,000 төгрөгийн үнийн саналтай тендерийг ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт хөдөлмөр хамгааллын хэрэгсэл нийлүүлэх ХӨАНЭ/202201023/ дугаартай тендерт "Санаа мед трейд" ХХК-ийн ирүүлсэн 55,461,090 / Тавин таван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга ерэн / төгрөгийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Иймд "Санаа мед трейд" ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулна уу.

Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа дараах зүйлийг анхаарна уу.

1. Шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хуулийн хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл хүргүүлэх,
2. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах,
3. Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон барааны нэгжийн үнэ өөрчлөгдөхгүй байхаар бараа нийлүүлэлтийн хуваарьт тусгаж, нийт үнээр гэрээ байгуулна.
4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу www.shilendans.gov.mn сайт болон орон нутгийн цахим сайтад тендершалгаруулалтын ерөнхий мэдээллийг тендер нээсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор байршуулах,
5. Гэрээ байгуулахад оролцсон төрийн албан хаагчдаас "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг бөглөж Авилгатай тэмцэх газрын сайтад шивж оруулах,
6. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэх,

7. Санхүүжилтийн хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, бараа бүрийн техникийн тодорхойлолтыг захиалагч, гүйцэтгэгчээр баталгаажуулж гэрээнд хавсаргах,
8. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд: Гэрээний нэр, үнэ, өртөг, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулсны дараа гүйцэтгэгчид санхүүжилт олгох тухай зааж өгөх.

Хавсрал 1 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.21 № 1/105

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллагын хүсэлтийн дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт нормын хувцас, зөөлөн эдлэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАНЭ/202201020 дугаартай худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад "Дээд хангай" ХХК 41,788,737 төгрөгийн, "Хөвсгөл-Иргэн" ХХК 42,459,000 төгрөгийн үнийн саналтай тендерүүдийг тус тус ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт нормын хувцас, зөөлөн эдлэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАНЭ/202201020 дугаартай тендерийг 41,788,737 (Дөчин нэгэн сая долоон зуун наян найман мянга долоон зуун гучин долоон) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн "Дээд хангай" ХХК-ийн тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд уг төсөлд "Дээд хангай" ХХК -тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

"Хөвсгөл-Иргэн" ХХК-ийн ирүүлсэн тендер нь шалгарсан оролцогчоос 670,263 /Зургаан зуун далан мянга хоёр зуун жаран гурван/ төгрөгөөр өндөр үнийн саналтай байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаагүй тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа дараах зүйлийг анхаарна уу.

Шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хуулийн хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл хүргүүлэх,

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш

0712010022

ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах,

Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон барааны нэгжийн үнэ өөрчлөгдөхгүй байхаар бараа нийлүүлэлтийн хуваарьт тусгаж, нийт үнээр гэрээ байгуулна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу www.shilendans.gov.mn сайт болон орон нутгийн цахим сайтад тендер шалгаруулалтын ерөнхий мэдээллийг тендер нээсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор байршуулах,

Гэрээ байгуулахад оролцсон төрийн албан хаагчдаас "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг бөглөж Авилгатай тэмцэх газрын сайтад шивж оруулах,

Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэх,

Санхүүжилтийн хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, бараа бүрийн техникийн тодорхойлолтыг захиалагч, гүйцэтгэгчээр баталгаажуулж гэрээнд хавсаргах,

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд: Гэрээний нэр, үнэ, өртөг, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулсны дараа гүйцэтгэгчид санхүүжилт олгох тухай зааж өгөх.

Тендерийн баримт бичгийг хавсаргаж хүргүүлэв.

Хавсралт ........ хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
Утас: 7038 8849; 7038 8821, Факс: 7038 8848
Э-майл: khuvsgul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http:/umch.khs.gov.mn

2022.02.22 № 1/109

танай ____________-ны № ____________-т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллагын хүсэлтийн дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт шатахуун тослох материал нийлүүлэх ХӨАНЭ/202201018/ дугаартай тендерийг www.tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад доор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт шатахуун тослох материал нийлүүлэх ХӨАНЭ/202201018/ дугаартай тендер шалгаруулалтад "Шунхлай Петролиум" ХХК 63,778,092 төгрөгийн, "Нэмэн" ХХК 62,756,898 төгрөгийн үнийн саналтай тендерүүд ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт шатахуун тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАНЭ/202201018 дугаартай тендерийг 63,788,092 (Жаран гурван сая долоон зуун наян найман мянга ерэн хоёр) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн "Шунхлай Петролиум" ХХК-ийн тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд уг төсөлд "Шунхлай Петролиум" ХХК -тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

"Нэмэн" ХХК-ийн ирүүлсэн тендер нь тендер нээх өдрийн байдлаар нийгмийн даатгалын өртэй байгаа тулТөрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтыг хангаагүй тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа дараах зүйлийг анхаарна уу.

1. Шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хуулийн хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл хүргүүлэх,
2. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах,
3. Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон барааны нэгжийн үнэ өөрчлөгдөхгүй байхаар бараа нийлүүлэлтийн хуваарьт тусгаж, нийт үнээр гэрээ байгуулна.
4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу www.shilendans.gov.mn сайт болон орон нутгийн цахим сайтад тендершалгаруулалтын ерөнхий мэдээллийг тендер нээсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор байршуулах,
5. Гэрээ байгуулахад оролцсон төрийн албан хаагчдаас "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг бөглөж Авилгатай тэмцэх газрын сайтад шивж оруулах,
6. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэх,

7. Санхүүжилтийн хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, бараа бүрийн техникийн тодорхойлолтыг захиалагч, гүйцэтгэгчээр баталгаажуулж гэрээнд хавсаргах,
8. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд: Гэрээний нэр, үнэ, өртөг, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулсны дараа гүйцэтгэгчид санхүүжилт олгох тухай зааж өгөх.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ